

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 65.020; 03.120.01

Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавигдах шаардлагууд	MNS ... : 2020
Англи нэр	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны ...-р сарын ...-ний өдрийн ... дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Зорилго

Мал, амьтны тавлаг байдлын таван эрх чөлөөг хангах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, бэлчээрийн мал аж ахуйн анхан шатны үйлдвэрлэгчийн түвшинд хариуцлагатай нүүдэлчин тогтолцоог хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим, шаардлагуудыг тогтоох, тэдгээрийг үнэлэх, баталгаажуулахад оршино.

2. Хамрах ба хэрэглэх хүрээ

2.1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч этгээд, сум, баг, малчдын бүлэг, хоршоо, сургалт болон тохирлын үнэлгээний байгууллагуудад хамаарна.

2.2. Хэрэглэх хүрээ

Энэхүү стандартыг бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч этгээд, сум, баг, малчдын бүлэг, хоршоо, сургалт болон тохирлын үнэлгээний үйлдвэрлэгчид болон тохирлын үнэлгээний байгууллагууд Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавигдах үндсэн зарчим, шаардлагуудыг тогтоох, хэрэгжилтэнд үнэлгээ өгөхөд хэрэглэнэ.

3. Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг ашигласан бөгөөд хэрэв эдгээр стандартад өөрчлөлт орвол хамгийн сүүлчийн албан ёсны эх материалыг баримтлана. Үүнд:

- MNS 1-1:2006 Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 1-р хэсэг
- MNS 1-2:2006 Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 2-р хэсэг
- MNS ISO/IEC 17067:2014 Тохирлын үнэлгээ. Бүтээгдэхүүний баталгаажуулалтын үндсэн асуудал ба бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн заавар
- MNS ISO/IEC 17021-1:2016 Тохирлын үнэлгээ. Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага. 1-р хэсэг

- ISO 19011:2016 Удирдлагын тогтолцоонд аудит явуулах заавар
- MNS ISO 14001

4. Нэр томьёо, тодорхойлолт

4.1. Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадал

Бэлчээр ашиглах, малын арчилгаа маллагааг хангах, үржүүлэг, селекцийг удирдан явуулах, эрүүл мэндийг хамгаалах болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэхэд тавигдах шаардлагуудыг хангахад зориулагдсан цогц үйл ажиллагаа;

4.2. баталгаажуулалтын схем

стандарт, удирдамж, сургалт, удирдлага, аудит, баталгаажуулалтын үйл явцыг багтаасан тогтолцоо, дүрэм, журам;

4.3. схем эзэмшигч

тухайн баталгаажуулалтын схемийг боловсруулах болон хэрэгжүүлэх хариуцлага хүлээх хувь хүн буюу байгууллага;

(схем эзэмшигч нь баталгаажуулалтын байгууллага, төрийн эрх бүхий байгууллага, худалдааны холбоо, баталгаажуулалтын байгууллагын бүлэг болон бусад байгууллага байж болно);

4.4. үнэлгээ

4.4.1. өөрийн үнэлгээ

Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг хэрэгжүүлэх бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч этгээд, баг, сум, малчдын бүлэг, хоршоо нь өөрийн үйл ажиллагааг энэхүү стандартад заасан шаардлага, шалгуураар үнэлж, үл тохирлоо илрүүлэх, залруулах, сайжруулах, баталгаажуулалтад бэлтгэх цогц үйл ажиллагаа;

4.4.2. хөндлөнгийн үнэлгээ

Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлсэн байдлыг энэхүү стандартад заасан шаардлага, шалгуураар эрх бүхий этгээд үнэлж, дүгнэлт өгөх цогц үйл ажиллагаа;

4.5. баталгаажуулалт

Итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаас Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлын шаардлага, шалгуурт тохирч байгаа тухай баталгааг бичгээр гаргасан шийдвэр;

4.6. баталгаажуулалтын байгууллага

Баталгаажуулалтын схемийг хэрэгжүүлэгч гуравдагч талын тохирлын үнэлгээний байгууллага буюу Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлснийг шалгаж нотлох эрх бүхий байгууллага.

4.7. Аудит

үйл ажиллагаа ба холбогдох үр дүн нь төлөвлөсөн зорилгод нийцэж байгаа эсэхийг тогтооход чиглэсэн, чиг үүргийн хувьд бие даасан, байнгын хяналт, үнэлгээ;

5. Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэх үйл ажиллагаа

5.1. Үндсэн зарчим:

- 5.1.1.** Уламжлалт нүүдлийн мал аж ахуйн арга ажиллагааг нийгэм, эдийн засаг, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулж боловсронгуй болгож, хариуцлагын тогтолцоог хөгжүүлэх;
- 5.1.2.** Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхдээ мал аж ахуйн тогтвортой байдлыг хангах, малчид, боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчид, хэрэглэгчид зэрэг оролцогч талууд харилцан итгэлцэл, үнэн зөв мэдээлэлд тулгуурлах;
- 5.1.3.** Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг сайн дурын үндсэн дээр нэвтрүүлэх бөгөөд хэрэгжилтийн үе шатуудыг үнэлгээ, баталгаажуулалтын үндсэн дээр нийгмийн дунд хүлээн зөвшөөрөгдөх;

5.2. Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг хэрэгжүүлэгчийн чиг үүрэг:

- 5.2.1.** Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлын стандартын шаардлагыг хангах;
- 5.2.2.** Боловсруулсан шалгуур, шаардлагын дагуу үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ хийх;
- 5.2.3.** Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг хэрэгжүүлсэн талаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, баталгаажуулах хүсэлтийг гаргах;
- 5.2.4.** Хөндлөнгийн эрх бүхий этгээдээр үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах;
- 5.2.5.** Үл тохирлыг залруулах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

5.3. Баталгаажуулалтын байгууллагын бүтэц, чиг үүрэг:

- 5.3.1.** Баталгаажуулалтын байгууллага нь орон тооны болон орон тооны бус шинжээч болон зөвлөлтэй байх;
- 5.3.2.** Мэргэжлийн шинжээчдийг сургах, давтан бэлтгэх;
- 5.3.3.** Хүсэлт гаргагчийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх;
- 5.3.4.** Бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч этгээд, баг, сум, малчдын бүлэг, хоршооны хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлын үйл ажиллагаанд газар дээр нь үнэлгээ хийх;
- 5.3.5.** Энэхүү стандартын шалгуурыг хангаж байгааг нотлохдоо холбогдох эх сурвалжийн мэдээлэл, үнэлгээний багийн тайлан, холбогдох бусад мэдээлэлд үндэслэх;
- 5.3.6.** Үл тохирлыг засан залруулах хугацааг зааж, сайжруулахыг санал болгох;

- 5.3.7. Баталгаажуулалтын үнэлгээний тайланг Баталгаажуулалтын зөвлөлд тайлагнах;
- 5.3.8. Баталгаажуулалтын шийдвэр гаргах, гэрчилгээ олгох;
- 5.3.9. Гэрчилгээ авсан байгууллага нь стандартын шаардлагыг үргэлжлүүлэн хангаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд жил бүр магадлах шалгалтыг хийх;
- 5.3.10. Магадлах шалгалтыг анхны баталгаажуулалтаас хойш 12 сарын дотор хийж гүйцэтгэх;
- 5.3.11. Тодорхой шалтгааны улмаас магадлах шалгалтыг 2 сар хүртэлх хугацаагаар хойшлуулж болно.

5.4. Сургалтын байгууллагын чиг үүрэг:

- 5.4.1. Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэх сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах;
- 5.4.2. Эрх бүхий этгээд шинжээч, сургагч нарт сургалт явуулах, гэрчилгээ олгох;

6. Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг, тэдгээрийн боловсруулалт

6.1 Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт бичгүүд:

- 6.1.1. **Тохирлын үнэлгээний байгууллагын дүрэм, журмууд** Энэхүү баримт бичигт гарын авлага, аудит хийх, баталгаажуулалт хийх дүрэм, журам, гэрчилгээ, тэмдэг, тэмдэглэгээ, шошго ашиглах болон бусад дүрэм журмууд хамаарна. Схем эзэмшигч нь эдгээр дүрэм, журмыг боловсруулж эрх бүхий байгууллагаар баталгаажуулна.
- 6.1.2. **Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэх, үнэлэх баримт бичиг** Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадалд тавигдах шаардлагууд нь дараах баримт бичгээс бүрдэнэ. Үүнд:
 - 1. Малын бэлчээрт тавигдах шаардлага
 - 2. Малын арчилгаа, маллагаанд тавигдах шаардлага
 - 3. Малын эрүүл мэндэд тавигдах шаардлага
 - 4. Малын үржүүлэгт тавигдах шаардлага
 - 5. Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэхэд тавигдах шаардлага
- 6.1.3. **Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг хэрэгжүүлэх удирдамж** Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд холбогдох гарын авлага, зөвлөмжийг мөрдлөг болгоно.

7. Удирдлагын менежмент

7.1 Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч этгээд, баг, сум, малчдын бүлэг, хоршоо нь жил бүр өөрийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг засах арга хэмжээ авдаг байна.

7.2 Түүхий эд бэлтгэх ажлыг малчин өөрөө эсвэл насанд хүрсэн хүнийг хяналтандаа хөлслөн ажиллуулна. Насанд хүрээгүй (16 түүнээс доош) хүүхэд ажиллуулахыг хориглоно.

8. Малын бэлчээрт тавигдах шаардлага

8.1 Бүртгэл хөтлөлт, төлөвлөлт

8.1.1 Бэлчээрт жил бүр мониторинг хийнэ.

8.1.2 Бэлчээр ашиглагчдын хэсэг бүлгийн болон улирлын бэлчээрийн хэмжээ байршил тогтоосон байна.

8.1.3 Бэлчээр ашиглах төлөвлөгөөг жил бүр газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусган Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж ажилладаг байна.

8.1.4 Бэлчээр ашиглах журмыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж, хууль зүйн яамны захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд бүртгүүлнэ.

8.1.5 Бэлчээр ашиглах гэрээг сумын Засаг даргатай байгуулна.

8.1.6 Бэлчээр ашиглах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэнэ.

8.2 Бэлчээрийн менежмент

8.2.1 Бэлчээрийн унаган ургамлын эзлэх хувь хэмжээ зохистой түвшинд байна. (Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас батлагдсан арга зүйн дагуу Хэсэг, бүлгийн улирлын бэлчээр тус бүр хийсэн мониторингийн судалгааны жил бүрийн мэдээллийг үндэслэн Лавлагаа түвшин дэх зүйлийн бүрэлдхүүний 60 хувиас доошгүй зүйлийг агуулах болон Зүйлийн бүрэлдхүүний хувьд суурь оны түвшинтэй тэнцүү буюу илүү байна)

8.2.2 Малчдын хэсэг бүлгийн гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн ургац, бүтцийг жил бүр нэмэгдүүлж сайжруулсан байна.

8.2.3 Малчдын хэсэг, бүлгүүд гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн төлөв байдал (сэргэх чадавхаар 1-5 ангилна) чанарыг доройтуулахгүй ашиглана. /Мониторингийн цэг тус бүрийн тухайн жилийн бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал” нь суурь онтой харьцуулан үзэхэд I-I; I-II; II-I; II-II түвшинд байгаа нөхцөлд эрүүл соргог гэж үзэх ба сэргэх чадавхийн түвшинг ашиглалтийн арга ажиллагаар ахиулсан буюу III-I; IY-I; III-II; III-III; IY-II; IY-III түвшинд байгаа бол мөн адил эрүүл соргог гэж үзнэ.

8.2.4 Малын тоог бэлчээрийн даацад тохируулах арга хэмжээг хэрэгжүүлнэ

8.2.4.1 Бэлчээрийн даац хэтрэлт хэсэг бүлгийн хэмжээнд 120 хувиас илүүгүй байна.

- 8.2.4.2 Бэлчээрийн ачаалал суурь жилтэй харьцуулахад нэмэгдээгүй байна.
- 8.2.5 Бэлчээрийг сайжруулах тогтвортой ашиглах зорилгоор дараах арга хэмжээг авсан байна:
 - 8.2.5.1 Хэсэг, бүлгийн бэлчээрийг ашиглах улирлын хуваарь тодорхой байна.
 - 8.2.5.2 Бэлчээрийн ачаалал бууруулах ногоон конвейер болон тэжээл тариалдаг байна.
 - 8.2.5.3 Малчин өрхийн жилийн дундаж нүүдлийн тоо 4 ба түүнээс дээш байна.
- 8.2.6 Малчдын хэсэг, бүлгийн түвшинд бэлчээрийн даацыг барих сүргийн эргэлтийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна.
- 8.2.7 Бэлчээрийг тордон сайжруулах арга хэмжээг хамтын хүчээр зохион байгуулах, төлөвлөгөө боловсруулах, төсөв санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зэргээр санаачлага гарган ажиллана.
 - 8.2.7.1 Бэлчээр, хадлангийн хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх; /стандартыг дурдах/
 - 8.2.7.2 Өнгөн хөрсний доройтлыг бууруулах, хөрсөн дэх карбонь шингээлтийг нэмэгдүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх;
 - 8.2.7.3 Хог цэвэрлэх, хорт ургамалтай тэмцэх.
- 8.2.8 Жилийн дөрвөн улиралд малын бэлчээрийн усан хамгамж хүрэлцээтэй байна.
 - 8.2.8.1 Өвөл
 - 8.2.8.2 Хавар
 - 8.2.8.3 Зун
 - 8.2.8.4 Намар
- 8.2.9 Малын тэжээл, усан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажил үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг хэсэг, бүлгийн хэмжээнд тогтмол зохион байгуулсан байна.

8.3 Малчдын хамтын ажиллагаа

- 8.3.1 Бэлчээр нутгаа уламжлалаараа хамтран ашиглаж ирсэн малчид хэсэг бүлгийн зохион байгуулалтад орсон байна.
 - 8.3.1.1 Хэсэг бүлгийн хурлын 70-аас дээш хувьд оролцоно.
 - 8.3.1.2 Хэсэг бүлэг бүх гишүүдийн хурлаар батласан дотоод дүрэмтэй байна.

- 8.3.1.3** Дотоод дүрмээ бүх гишүүд батлаж гарын үсэг зурна.
- 8.3.2** Сумын Засаг дарга малчдын хэсэг, бүлэгтэй талуудын эрх, үүргийг тодорхой тусгасан бэлчээр ашиглах гэрээг урт хугацаатай байгуулж жил бүр хэрэгжилтийг дүгнэнэ.
- 8.3.3** Бэлчээр ашиглуулах гэрээ газрын кадастарын мэдээллийн санд бүртгэгдэнэ.
- 8.3.4** Бэлчээр ашиглах гэрээнд дараах мэдээллүүдийг оруулж газрын кадастерийн мэдээллийн санд бүртгэгдэнэ.
 - 8.3.4.1** малчдын мэдээлэл,
 - 8.3.4.2** Хэсэг, бүлгийн улирлын бэлчээрийн хил заагийн зураг,
 - 8.3.4.3** фотомониторингийн мэдээлэл,
 - 8.3.4.4** Бэлчээрийн экологийн чадавхийн зураг
 - 8.3.4.5** Сүргийн эргэлтийн төлөвлөгөө
- 8.3.5** Малчид үр ашигтай хэлбэрээр хоршиж ажиллах замаар түүхий эд бэлтгэлийн анхан шатны хоршооны зохион байгуулалтад орсон байна.
 - 8.3.5.1** Гишүүд хоршоондоо түүхий эдээ тогтмол нийлүүлнэ
 - 8.3.5.2** Хоршоо нь малчдын бэлтгэсэн түүхий эд бүтээгдэхүүний анхан шатны тордолт хийх, тээвэрлэлт, зах зээлд нийлүүлэх, нэмүү өртөг шингээх, орлого, ашгийг хувиарлах зэрэг ажлыг хариуцлагатайгаар гүйцэтгэнэ
- 8.3.6** Хоршоо нь түүхий эдээ бэлтгэх, тээвэрлэх, хадгалах, тордолт хийх, материаллаг баазийг бүрдүүлнэ.
- 8.3.7** Малчдын хэсэг, бүлгүүд бэлчээр ашиглагчдын холбооны бүтэц, зохион байгуулалтад орж бэлчээр ашиглалтаа сайжруулна.

9 Малын тэжээллэг, арчилгаа, маллагаанд тавигдах шаардлага

9.1 Малын арчилгаа

- 9.1.1** Малын төрөл, нас, хүйс, ашиг шимийн чиглэл, бүс нутгийн экологийн онцлог, анатоми, физиологийн хэрэгцээ, шаардлагыг хангасан өвөлжөө, хаваржааны зориулалтын хашаа, саравч, хороо, байртай байна.
- 9.1.2** Зун, намаржааны зөөврийн хашаа, тоног төхөөрөмжтэй байна.
- 9.1.3** Зун, намар малаа хашдаггүй байна
- 9.1.4** Малын хэвтэр бууцыг байнга цэвэр байлгана.
- 9.1.5** Оны эхний малд зүй бусаар хорогдсон том малын эзлэх хувь /сүүлийн 3 жилийн дунджаар/
 - 9.1.5.1** бод малд 4 хүртэл хувь

9.1.5.2 бог малд 6 хүртэл хувь

9.1.6 Оны эхний малд өвчнөөр хорогдсон малын эзлэх хувь /сүүлийн 3 жилийн дундажаар/

9.1.6.1 бод малд 0.5 хүртэл хувь

9.1.6.2 бог малд 1 хүртэл хувь

9.1.7. Эвэр, сүүл тайрах зэрэг малд стресс үзүүлдэг арчилгаа, маллагааны технологиос татгалзсан байна.

9.2. Малын бэлчээр, тэжээлийн хангамж, хүрэлцээ, тэжээллэг

9.2.1. Малын амьдралын болон ашиг шимийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц бэлчээр, тэжээлийн нөөц, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллана.

9.2.2. Мал сүргийг жилд 120-оос дээш хоногийн хугацаанд байгалийн бэлчээрт бэлчээрлүүлнэ.

9.2.3. Өвөлжилт, хаваржилтад зориулж малд өгөх өвс, нэмэгдэл тэжээл бэлтгэж нөөцлөх ба 30-аас даашгүй хоногт хүрэлцэхүйц байна.

9.2.4. Бэлчээрийн малд өвөл, хаврын үед нэмэгдэл тэжээл өгөх нормативыг хангана

9.2.4.1. хонь, ямаа, үхрийн 50 хувь

9.2.4.2. тэмээний 10 хувь

9.2.4.3. адууны 4 хувийг тэжээх

9.2.5. Малд давс, хужир зэрэг эрдэс тэжээл өгч, бүртгэл хөтөлсөн байна.

9.2.6. Малын тэжээлд чанар, эрүүл ахуйн үнэлгээ, баталгаажуулалт хийлгэнэ.

9.2.4 Хадлан, тэжээлийн ургамал тариалалтанд зөвхөн органик бордоог зааврын дагуу хэрэглэнэ.

9.2.5 Малын тэжээлд хими, биологи, эмийн бодис (антибиотик) нэмэлтээр ашиглахгүй.

9.2.6 Малыг норм, жорын дагуу тэжээнэ.

9.3 Малын усан хангамж

9.3.4 Усан хангамжийн өөрийн эх үүсвэртэй байна.

9.3.5 Малын чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар бүрэн хангадаг байна.

9.3.6 Усны чанар, эрүүл ахуйн үнэлгээ зохих байгуулгаар хийлгэсэн байна.

9.3.7 Худагтай болоход малчин хөрөнгө оруулалт хийнэ.

9.4 Мал хариулах, туух, тээвэрлэх үеийн аюулгүй ажиллагаа

- 9.4.1 Малаа хариулах, тууварлахдаа мотоцикл, машин ашигладаггүй, ердийн хөсөг ашиглан тааваар нь идээшлүүлнэ.
- 9.4.2 Мал тууварлахдаа ердийн хөсөг /адуу, тэмээ, үхэр, сарлаг/ хэрэглэнэ
- 9.4.3 Малыг тээвэрлэхдээ зориулалтын тусгайлан бэлтгэсэн тээврийн хэрэгсэл хэрэглэнэ
- 9.4.4 Малыг хаших, хариулах, тээвэрлэхдээ хүчтэй, хатуу зүйлээр цохиж, ороолгох, чанга орилох зэргээр айлгаж, цочоож, тамлан зовоохгүй.
- 9.4.5 Малыг хаших, уях, хөтлөх, ногтлох, хазаарлахдаа уламжлалт аргаар сур, дээс, хялгас ашиглах, гэмтэл учруулахгүй, айдас төрүүлэхгүй тавлаг байдлыг хангана.

9.5 Байгаль орчин

- 9.5.1 4 улиралд нүүдэлж байршсан газрын орчмын хогийг цэвэрлэж, ул мөр бага үлдээхэд анхаарна.
- 9.5.2 Өвөлжөөний хөрсөнг жил бүр авах ба түлшинд ашиглана.
- 9.5.3 Үхрийн баасыг цуглуулж хатаах ба буцааж түлшинд ашиглана.
- 9.5.4 Бог малын хорголыг хатааж бууц болгон ашиглана.
- 9.5.5 Ахуйн хогийг төвлөрсөн цэгт байршуулж, устгана.
- 9.5.6 Малын гаралтай хаягдлыг дахин боловсруулж ашиглана.

10. Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг, селекцид тавигдах шаардлага

10.2. Бүртгэл хөтлөлт, төлөвлөлт

10.2.1. Мал сүрэгт дараах бүртгэлийг хөтөлдөг байна.

- 10.2.1.1. цөм сүргийн бүртгэл
- 10.2.1.2. үржлийн сүргийн бүртгэл
- 10.2.1.3. хэрэгцээний сүргийн бүртгэл
- 10.2.1.4. мал төллөлтийн бүртгэл

10.2.2. Үржлийн малд хянан баталгаажуулалт хийлгэсэн байна

- 10.2.2.1. нийт хээлтүүлэгчийн 90 ба түүнээс дээш хувьд үржлийн гэрчилгээ авсан
- 10.2.2.2. нийт хээлтэгчийн 80 ба түүнээс дээш хувьд үржлийн гэрчилгээ авсан

- 10.3. Малчин, мал бүхий этгээд нь Үндэсний статистикийн хорооны мал, тэжээвэр амьтдын жил тутмын тооллогын мэдээллийн санд бүртгэгдсэн байна.
- 10.4. Малчин нь Үндэсний статистикийн хорооны мал, тэжээвэр амьтдын жил бүрийн тооллогын мэдээллийн санд мал сүргээ үүлдэр, омог, хээлтэгч, хээлтүүлэгчээр нь ялган бүртгүүлсэн байна.

10.4.1. Малын борлуулалт, шилжилт хөдөлгөөний талаар мэргэжлийн байгууллагад мэдээлнэ

10.4.2. Мал маллах, мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааны талаар бүртгэл хөтөлнө

10.5. Малын ашиг шим, бүтээмж

10.5.1 Нэг малаас авч буй ноос, ноолуурын ашиг шимийн дундаж гарц дараах шаардлагыг хангасан байна

10.5.1.1. ноос 1200 гр-аас дээш

10.5.1.2. ноолуур 270 гр-аас дээш

10.5.2 Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд чанарын үнэлгээ хийлгэнэ

10.5.2.1 ноосны урт

10.5.2.2 ноолуурын микрон

10.5.2.3 сүүний тослог

10.5.2.4 арьс ширний ашигтай талбай

10.5.3 Малын намрын амьдын жин дараах шаардлагыг хангасан байна

10.5.3.1 4 настай адуу 380 кг ба түүнээс дээш

10.5.3.2 4 настай үхэр 330 кг ба түүнээс дээш

10.5.3.3 4 настай сарлаг 280 кг ба түүнээс дээш

10.5.3.4 4 настай тэмээ 440 кг ба түүнээс дээш

10.5.3.5 3 настай хонь 50 кг ба түүнээс дээш

10.5.3.6 3 настай ямаа 45 кг ба түүнээс дээш

10.5.4 Малын махны гулуузны жин дараах шаардлагыг хангасан байна

10.5.4.1 2 настай бод малын гулуууны жин 120 кг-аас дээш

10.5.4.2 2 настай бог малын гулуууны жин 18 кг-аас дээш

10.5.5 Малаас авч байгаа ашиг шимд эерэг өөрчлөлт гарч байгаа эсэх

10.6. Малын үржүүлэг, селекци

10.3.1 Малын үүлдэрлэг байдал, бүс нутаг байгаль экологийн нөхцөл, чадамж, төрийн бодлогод нийцсэн мэргэжлийн үйлчилгээ авдаг байна.

10.3.2 Мал, амьтандаа жил бүр тогтоосон хугацаанд ангилалт хийлгэж, шилэн сонголт, заазлалтыг тогтмол хийлгэдэг байна.

10.3.3 Малын үржлийн ажлын бүртгэл хөтөлнө.

10.3.4 Аж ахуйн онцлогт тохирсон малын хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо, тохируулан сонголтыг хийдэг байна.

10.3.5 Аж ахуйн технологийн онцлогт тохирсон малын үржүүлгийн ажлыг зохион байгуулдаг байна.

10.3.6 Аж ахуйн онцлогт тохирсон малын хээлтүүлэг /дур зоргын, гардан, зохиомол/-ийн аргыг сонгож ашигладаг байна.

10.3.7 Малын өсөлт, хөгжилт, ашиг шимийн гарц, чанар, тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлүүдийн судалгааг мэргэжлийн байгууллага, мэргэжилтнээр хийлгэж үнэлэлт, дүгнэлтийг үйл ажиллагаандаа нэвтрүүлдэг байна.

10.6.1. Мал сүргийн үүлдэрлэг байдал зөвшөөрөгдсөн бүс нутагт нийцэж байгаа эсэх

10.6.1.1. адууны үүлдэр

10.6.1.2. үхрийн үүлдэр

10.6.1.3. тэмээний үүлдэр

10.6.1.4. хонины үүлдэр

10.6.1.5. ямааны үүлдэр

10.6.2. Хээлтүүлэгчийг сонгох арга

10.6.2.1. өөрийн хотноос сонгон тавьдаг

10.6.2.2. хуц, ухна маллагчаас авч тавьдаг

10.6.2.3. мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжээс сонгон тавьдаг

10.6.3. Хээлтүүлэгчийн хүрэлцээ дараах тогтоосон нормд байна:

10.6.3.1. 12-15 гүүнд нэг азарга

10.6.3.2. 35-45 үнээнд нэг бух

10.6.3.3. 20-25 ингэнд нэг буур

10.6.3.4. 30-40 эм хонинд нэг хуц

10.6.3.5. 30-40 эм ямаанд нэг ухна

10.6.4. Мал үржүүлэг, технологийн нэгжтэй гэрээ байгуулж ажилладаг эсэх

10.6.5. Мал сүргийг жил бүр үзлэг ангилалтанд хамруулдаг эсэх

10.7. Малын нөхөн үйлдвэрлэл

10.7.1. Мал сүргийн бүтэц дараах шаардлагыг хангасан байна

10.7.1.1. Сүрэгт бод малын эзлэх хувь 15 ба түүнээс дээш

- 10.7.1.2.** Сүрэгт бог малын эзлэх хувь 85 ба түүнээс доош
- 10.7.2.** Сүрэгт хээлтэгчийн эзлэх хувь дараах шаардлагыг хангасан байна.
 - 10.7.2.1.** бод малд 40 ба түүнээс дээш хувь
 - 10.7.2.2.** бог малд 50 ба түүнээс дээш хувь
- 10.7.3.** Сувайрсан эх малын оны эхний хээлтэгчид эзлэх хувь дараах хязгаарт байна.
 - 10.7.3.1.** гүү (20 хүртэлх хувь)
 - 10.7.3.2.** үнээ (15 хүртэлх хувь)
 - 10.7.3.3.** ингэ (3 хүртэлх хувь)
 - 10.7.3.4.** эм хонь (10 хүртэлх хувь)
 - 10.7.3.5.** эм ямаа (14 хүртэлх хувь)
- 10.7.4.** Эдийн засгийн эргэлтэнд оруулсан эр сувай малын оны эхний малд эзлэх хувь
 - 10.7.4.1.** бодын сүрэгт 15 ба түүнээс дээш хувь
 - 10.7.4.2.** богийн сүрэгт 35 ба түүнээс дээш хувь
- 10.7.5.** Тухайн жилийн төл бойжилтын хувь дараах шаардлагыг хангаж байна.
 - 10.7.5.1.** адуун сүрэгт 95 ба түүнээс дээш хувь
 - 10.7.5.2.** үхэр сүрэгт 96 ба түүнээс дээш хувь
 - 10.7.5.3.** тэмээн сүрэгт 97 ба түүнээс дээш хувь
 - 10.7.5.4.** хонин сүрэгт 95 ба түүнээс дээш хувь,
 - 10.7.5.5.** ямаан сүрэгт 93 ба түүнээс дээш хувь

11. Малын эрүүл мэндэд тавигдах шаардлага

- 11.2.** Малын гоц халдварт болон зооноз өвчингүй, тайван байдал хангагдсан, эсхүл эрсдэл бүхий халдварт өвчнөөс хамгаалах дархлаа тогтсон мал сүрэгтэй байх.
 - 11.2.1.** Тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Мал эмнэлгийн байгууллагатай жил бүр гэрээ байгуулан хамтран ажиллаж, мал сүргээ малын эмчийн байнгын хяналтад байлгана.
 - 11.2.2.** Бүс, нутгийн хэмжээнд, эсхүл тухайн аж ахуйн хэмжээнд нэр бүхий гоц халдварт болон зооноз өвчингүй статусыг мал эмнэлгийн байгууллагаас баталгаажуулан гэрчилгээ олгосон бол холбогдох зааврын дагуу жил бүр шинжилгээ хийлгэж тухайн статусыг тогтвортой хадгалж байгаагаа нотолно.
 - 11.2.3.** Хашаа, байрны ойр орчимд болон ашиглаж байгаа бэлчээрт үхсэн мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж, устгахын зэрэгцээгээр гэрээт малын эмчээр халдваргүйтгэл хийлгэнэ.

- 11.2.4.** Мал эмнэлгийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа төлөвлөгөөт болон яаралтай дархлаажуулалтын товлот хугацаанд мал сүргээ бэлэн байлгаж, бүрэн хамруулна.
- 11.2.5.** Мал сүрэгтээ өдөр тутмын хяналт тавих бөгөөд малд өвчний шинж тэмдэг илэрснээс хойш 12 цагийн дотор мал эмнэлийн байгууллагад мэдэгдэнэ.
- 11.3.** Малын шилжилт хөдөлгөөнийг хянах, биоаюулгүй байдлын анхан шатны арга хэмжээ хэрэгжүүлэх замаар тухайн сүрэгт гаднаас халдвар дамжих эрсдлийг бууруулсан байх.
- 11.3.1.** Мал маллах, ашиглах, эдлэх, тээвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан “Хашаа, байр, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, ариун цэврийн нийтлэг заавар”-ыг дагаж мөрдөнө.
- 11.3.2.** Гаднаас мал худалдан авахдаа түүний эрүүл мэндийн байдлыг онцгой анхаарах бөгөөд Мал эмнэлгийн гэрчилгээтэй тохиолдолд худалдан авна.
- 11.3.3.** Гэрээт мал эмнэлгийн байгууллагад дуудлага өгч мал тээвэрлэн ирж байгаа тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл хийлгэнэ.
- 11.3.4.** Худалдан авч байгаа болон ямар нэгэн арга хэмжээнд оролцоод буцаан авчирч байгаа малыг гэрээт мал эмнэлгийн байгууллагаас зөвлөсний дагуу хорио цээрийн хяналтад байлгасны дараа сүрэгт нийлүүлнэ.
- 11.3.5.** Саахалт айл болон хөрш фермийн халдварт өвчний эрсдэлийн талаар үнэлгээ хийлгэж, халдвараас хамгаалах үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлдэг байна.
- 11.3.6.** Зэрлэг амьтдаас байгалийн голомтот халдварт өвчин халдварлах эрсдэлтэй бэлчээрт малаа хариулгагүй бэлчээхээс зайлсхийхээс гадна эрсдэл бүхий зэрлэг амьтад хашаа, хороонд нэвтрэхээс хамгаалсан байна.
- 11.3.7.** Халдварт өвчин дамжуулах эрсдэлтэй шавж, мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 11.3.8.** Цэвэр тоног хэрэгсэл, багаж төхөөрөмж ашиглахыг чухалчлан үзэх ба бусдын хэрэглэж байсан тоног хэрэгсэл, багаж төхөөрөмжид халдваргүйтгэл хийлгэсний дараа ашиглана.
- 11.4.** Малын өвчнийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ хэрэгжүүлэх замаар тархалтыг богино хугацаанд хязгаарлах, малын эрүүл мэндийн түүхийг мөшгөх нөхцлийг бүрдүүлсэн байна.
- 11.4.1.** Бүх малыг ялган тэмдэглээгүй тохиолдолд халдварт өвчний тандалт шинжилгээнд сонгогдсон болон антибиотикийн эмчилгээ хийсэн малыг нэг бүрчлэн ялган тэмдэглэсэн байна.
- 11.4.2.** Улирал тутамд нэгээс доошгүй удаа малын эмч дуудаж мал сүрэгтээ эмнэл зүйн үзлэг хийлгэсэн байна.
- 11.4.3.** Халдварт өвчний сэжиг илэрсэн малд лабораторийн шинжилгээ хийх, өвчтэй малд эмчилгээ хийх хугацаанд тэдгээрийг сүргээс ялган тусгаарлах боломжийг бүрдүүлсэн байна.

- 11.4.4.** Эрсдэл бүхий шимэгчтэх өвчнөөс эрүүлжүүлэх нэгдсэн арга хэмжээний товллолт хугацаанд мал сүргээ бэлэн байлгаж, бүрэн хамруулсан байна.
- 11.4.5.** Өвчилсөн, гэмтсэн малд зайлшгүй шаардлагаар анхны тусламж үзүүлсэн иргэн тухайн үед хэрэглэсэн эм, бэлдмэлийн нэр, хүчинтэй хугацаа, тун хэмжээний талаарх мэдээллийг малын эрүүл мэндийн дэвтэрт тэмдэглэнэ.
- 11.4.6.** Өвчилсэн малын эмчилгээний талаарх тэмдэглэлийн хуулбарыг малын эмчээс авч малын эрүүл мэндийн дэвтэрт хавсаргасан байна.
- 11.5.** Малын эм болон төрөл бүрийн химийн бэлдмэлийн хэрэглээний зохистой дадлыг нэвтрүүлэх замаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц хэмжээний эмийн үлдэгдэл агуулаагүй, баталгаатай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг байна.
- 11.5.1.** Зөвшөөрөгдсөн химийн бэлдмэлийг зөвхөн гэрээт мал эмнэлгийн байгууллагаар дамжуулан авч ашиглана.
- 11.5.2.** Химийн бэлдмэлийг хэрэглэхдээ түүнийг хэрэглэх заавар, тун хэмжээ, зохистой хугацааг хатуу мөрдөнө.
- 11.5.3.** Жоргүй олгох эмийг хэрэглэхдээ гэрээт малын эмчээс заавар зөвлөмж авсан байна.
- 11.5.4.** Эмчилгээ, үйлчилгээнд жороор олгох эм хэрэглэх бол түүнийг зөвхөн малын эмч болон эрх бүхий этгээдээр хийлгэнэ.
- 11.5.5.** Дархлаажуулалт, угаалга, туулга, боловсруулалт зэрэг нэгдсэн арга хэмжээ болон эмийн эмчилгээний дараа хүлээх хугацааг үйлчилгээ үзүүлсэн малын эмч тогтоох бөгөөд уг хугацаа дуусаагүй үед малын мах, сүүг зах зээлд нийлүүлэхийг хориглоно.
- 11.5.6.** Малчин гэрээт малын эмчийн зөвлөмж зааварчилгаагүйгээр эм, химийн бэлдмэл худалдан авах, зориулалтын бус нөхцөлд хадгалах, малын эмчилгээнд дур мэдэн хэрэглэхийг хориглоно

12. Малын гаралтай түүхий эд бэлтгэлд тавигдах шаардлага

12.2. Бүртгэл хөтлөлт, төлөвлөлт

- 12.2.1.** Бэлтгэсэн түүхий эд бүтээгдэхүүний бүртгэл хөтөлнө.
- 12.2.2.** Борлуулсан түүхий эд, бүтээгдэхүүний бүртгэл хөтөлнө.
- 12.2.3.** Түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах талаарх төлөвлөгөө боловсруулан мөрдөж ажиллана.
- 12.2.4.** Түүхий эд бэлтгэх үед малд гэмтэл бэртэл үүссэн тохиолдолд бүртгэл хөтлөн, дариу эмчлэх, өвдөлт намдаах арга хэмжээ авна.

12.3. Ноос, ноолуур бэлтгэл

- 12.3.1.** Ноос, ноолуурыг дараахь стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.

- 12.3.1.1. MNS 6375:2013 Ноос, ноолуур.Түүхий эд бэлтгэл. Ямааны ноолуур. Техникийн шаардлага
- 12.3.1.2. MNS 0036:2015 Ноос, ноолуур.Түүхий эд бэлтгэл. Тэмээний ноос. Техникийн шаардлага
- 12.3.1.3. MNS 0033-2007 Ноос, ноолуур.Түүхий эд бэлтгэл. Хонины ноос. Техникийн шаардлага
- 12.3.1.4. MNS 6377:2013 Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Сарлагийн хөөвөр. Техникийн шаардлага
- 12.3.1.5. MNS 0070:2007 Ноос, ноолуур.Түүхий эд бэлтгэл. Хөөвөр. Техникийн шаардлага
- 12.3.2. Малыг барих, уяж бэхлэх, ноослохдоо малыг айлган цочоох, айдаст автуулах, ширүүн хандахыг цээрлэнэ.
- 12.3.3. Мал бүрийн зан ааш, галбир бүтцийн онцлогт тохируулан мал барих, бэхлэх (хүзүү, толгой, хөлийн бэхэлгээ) хэрэгслийг зөв сонгоно.
- 12.3.4. Малын уяа бэхэлгээг хийхдээ боохгүй, мултрахааргүй бөхөлж, хөвөрхий тооно туших аргыг хэрэглэнэ.
- 12.3.5. Мал ноослох багаж хэрэгсэл сам, хайч, хүлэх бэхлэх дээс зэрэг нь малд бэртэл гэмтэл үүсгэхгүй стандартын шаардлага хангасан байна.
- 12.3.6. Мал ноослохдоо осгох бээрэх, наранд цохиулахаас сэргийлэн сүүдрэвч ашиглах, нэмнэх арга хэмжээг авна.
- 12.3.7. Малын биед зовиур үүсгэх тул ноолуур үс нь хөөрөхөөс өмнө самнахыг цээрлэнэ.
- 12.3.8. Хөндийрөөгүй ноос, ноолуурыг зулгааж авахыг хориглоно.
- 12.3.9. Малын урт хялгас нь орооцолдон даахирч, самнах үед зулгаах, малыг өвтгөх магадлалтай тул урт хялгасыг эхэлж сэрмээд дараа нь малын арьсыг нь урж, гэмтээлгүйгээр болгоомжтой самнана.
- 12.3.10.Ноос, ноолуурыг самнаж авахдаа “MNS 1012:2016. Ноос, ноолуурын сам. Техникийн шаардлага” стандартад нийцсэн жигд иртэй самаар, үсний ширхгийг дагуулан зөөлөн самнаж авсан байна.
- 12.3.11.Хээлтэй малыг ноослохдоо олноор цуглуулж, шахцалдуулах, хүчтэй унагаах, эвгүй эргүүлж хөрвөөлгөх, хойт урд хөлөөс тэлж бэхлэн самнахыг хориглоно.
- 12.3.12.Хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган нас бие гүйцсэн бод малыг босоогоор нь, бага насны бод малыг болон бог малыг тусгай дэвсгэр дээр унагаж самнана.
- 12.3.13.Бод малыг хөөвөрлөхдөө адууг чөдөрлөх, үхэр, адууг шахах, ороох, унагаж хүлэх аргаар бэхлэнэ. Бод малыг ноослохоор барих, бэхлэх, ноослох явцад малыг айдас дарамтад учруулах цорводох, дөрлөх, чихдэж, чихийг мушгих, уурганы хуйв болон бугуйлаар боох, сүүлнээс татах, сүүлийг мушгих, ороох зэрэг аргуудыг хэрэглэхийг хориглоно.

12.4. Арьс шир бэлтгэл

- 12.4.1.** Арьс ширийг MNS 0060:2013 Түүхий эд бэлтгэл, Боловсруулаагүй арьс шир Техникийн шаардлага стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.
- 12.4.2.** Малыг нядлах (төхөөрөх) зорилгоор тээвэрлэсэн тохиолдолд малыг амрааж, ус тэжээлээр хангасан байна.
- 12.4.3.** Малыг төхөөрөхдөө стресс дарамтгүй хүмүүнлэг аргаар амийг таслан, стандартад заасан аргачлалын дагуу арьс, ширийг нь салгаж авна.
- 12.4.4.** Өвчихдөө эвэр, туурай, шийр, чих, уруул, чив, засаа, дэлэн, сүүл зэргийг арьсанд үлдээхгүй салгасан байна.
- 12.4.5.** Арьс ширийг өвчихдөө шар мах, өөх дагуулахгүй, урах, эсгэж, огтлохгүй, нүх гаргахгүйгээр гэмтэлгүй бэлтгэнэ.
- 12.4.6.** Арьс, ширийг өвчиж авмагц хоёр цагаас хэтрүүлэхгүй дэл, сүүл, эвэр туурай, чихний мөгөөс, халим, шар мах, арьсанд цус, наалдсан өвс хойг цэвэрлэсэн байна. Арьс ширнээс шар мах, өөхний үлдэгдлийг хянгар болон, зориулалтын хутга эсвэл зориулалтын машин ашиглан цэвэрлэж, MNS 5094:2001 Чанарын хамгаалалт хийх, баглах, тээвэрлэх, хадгалах стандартын дагуу чанарын хамгаалалт хийсэн байна.
- 12.4.7.** Арьс ширэнд чанарын хамгаалалт хийх, баглах, хадгалах үйл ажиллагааг стандартын шаардлага хангасан зориулалтын байранд явуулах ба зориулалтын тэврийн хэрэгслээр тээвэрлэнэ

12.5. Сүү бэлтгэл

- 12.5.1.** Сүүг дараахь стандартын шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ.
 - 12.5.1.1.** “MNS 4228:2011 Малыг түүхий сүү. Техникийн шаардлага
 - 12.5.1.2.** MNS 4229:2011 Эсэг цагаан идээ Техникийн шаардлага,
 - 12.5.1.3.** MNS 4230:2005 Уурагт цагаан идээ, Техникийн шаардлага,
 - 12.5.1.4.** MNS 4528:2011 Тослог цагаан идээ, Техникийн шаардлага
- 12.5.2.** Малыг саалийг ашиглахдаа бэлчээр, ногооны хүрэлцээ, зуншлага, төлийн өсөлт, тарга хүч авалттай уялдуулан саалийн хугацааг хэдийд эхлэх, өдөрт хэдэн удаа саахыг тогтооно.
- 12.5.3.** Малаа саахын өмнө гар болон хувин саваа тогтмол угааж цэвэрлэсэн байна.
- 12.5.4.** Саалинд ашиглаж буй тоног хэрэгсэл, арга технологи нь малд гэмтэл бэртэл учруулах, стресс дарамт үүсгэхээргүй, халдвар дамжуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 12.5.5.** Сүү сааль бэлтгэх үед айлгаж цочоох, хэт чанга туших, бэхлэх, бэлчээрлэлтийг оройтуулахаас сэргийлэх хэрэгтэй.

- 12.5.6. Саалинд сургаж байгаа малыг сааж дадлагажсан хүнээр саалгах, зөөлөн харьцаж элдэв буруу зуршил суухгүй байх, дэлэн хөхийг давстай бүлээн усаар угааж иллэг хийнэ.
- 12.5.7. Төл мөл, хөрвө эхээ хөхөхөөс хамгаалах зорилгоор хамарт шор, модон амгайвч зэргийг хэрэглэхийг хориглоно.
- 12.5.8. Малаа саах болон унага, тугал татах ажилд насанд хүрээгүй хүүхэд оролцуулахыг хориглоно.
- 12.5.9. Малыг саахдаа зүүн гараар дэлэнг зөөлөвтөр атгаж, баруун гарын эрхий долоовор хуруугаар хөхийг шувтарч саана.
- 12.5.10. Бог малыг холбож сааж байгаа үед хэт удаан холбоонд байлгах, олноор холбох, боогдуулах, холбоотой малыг үргээж цочоох, холбооны завсараар сул мал оруулахыг хориглоно.

12.6. Мал мах бэлтгэл

- 12.6.1. Малын махыг стандартын дагуу дараах стандартын дагуу бэлтгэсэн байна.
 - 12.6.1.1. “MNS 1111:2007 Үхэр, өсвөр үхэр, адууны өрөөл мах, хонь, ямаа, хурганы гулууз мах. Техникийн ерөнхий шаардлага”,
 - 12.6.1.2. “MNS 2457:2009 Мах, махан бүтээгдэхүүн. Хонь, ямааны хэсэглэж, ангилсан мах. Ерөнхий шаардлага” стандартуудыг дагаж мөрдөнө.
- 12.6.2. Малын тээвэрлэхдээ хэт олноор зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг хориглоно.
- 12.6.3. Тээвэрлэсэн малыг нядлахын өмнө амраан хангалттай ус, тэжээлээр хангана.
- 12.6.4. Идшинд төхөөрөх малыг удаан хугацаанд уяж өл хоолгүй байлгах, хол зайд тээвэрлэж байгаа бол 48-72 цаг амраасаны дараа нядалж төхөөрнө
- 12.6.5. Идшинд төхөөрөх малыг хүмүүнлэг аргаар стресс дарамт оруулахгүйгээр амийг таслана. Малыг зовоосон оновчтой бус, амь таслах аргыг буруу хэрэглэхийг хориглоно.
- 12.6.6. Бод ба богийн махыг ихэвчлэн 7 хөл мах болгон эвдэж бэлтгэхийн дээр гэдэс доторыг уламжлалт аргын дагуу арилгаж бэлтгэнэ.

ТӨГСӨВ.